

Зарим компанийн брокер, дилерийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 16 дугаар тогтоолын 3 дахь заалтаар өгөгдсөн үүргийг биелүүлээгүй “Масдак” ХХК, “Бумбат-Алтай” ХХК, “Эрдэнэст” ХХК, “Аргай бэст” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 сарын хугацаанд түдгэлзүүлсүгэй.

2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд энэ тогтоолын 1-д заасан компаниудыг үнэт цаасны арилжаанд оролцуулахгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд түдгэлзүүлэх болсон шалтгаан, нөхцөлийг арилгах, арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг дээрх Компаниудын удирдлагад анхааруулсугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ